

Хайрцаг

Савангийн үйлдвэр 10 см-ийн зузаан бүхий 1x1, 2x2, 3x3, 4x4, 5x5, 6x6 хэмжээтэй савангуудыг үйлдвэрлэдэг. Тэдгээрийг үйлдвэрээс дэлгүүр рүү ачихдаа тус бүрийг нь 10 см өндөртэй, 6x6 хэмжээтэй хайрцганд хийж гаргадаг. Энэ нь зардал ихтэй тул зарим хайрцганд нэгээс олон саван хийх замаар хамгийн багадаа хэдэн хайрцаг хэрэглэж болохыг ол. Нэг төрлийн саванг дээд тал нь 6000 ширхэг үйлдвэрлэдэг гэж үз.

Input

Оролт нь хэд хэдэн тестээс тогтоно. Мөр бүрт нэг тестийг тодорхойлно. Мөрөнд байгаа тоонууд нь харгалзан 1x1, 2x2, 3x3, 4x4, 5x5, 6x6 хэмжээс бүхий савангуудын тоог илэрхийлнэ. Оролтын төгсгөлд зургаан тэг бүхий мөр байрлана.

Output

Оролтонд байгаа тест бүрт харгалзах хайрцагны тоог нэг нэг мөрөнд гаргана. Тэгүүд бүхий сүүлийн мөрөнд зориулж хариулт гаргахгүй.

Example

Input:

```
0 0 4 0 0 1
7 5 1 0 0 0
0 0 0 0 0 0
```

Output:

```
2
1
```